



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/1937

Мандалговь

Монгол Улсын Их хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүд орон нутагт ажиллахтай холбогдуулан зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.5, Зардлын норматив батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалын зүйл гардуулах зардлын норматив”-ын 1 дүгээр хэсгийн 1.1 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд Ч.Номин нар бусад албаны дагалдах хүмүүсийн хамт орон нутагт ирж, боловсрол, соёл урлагийн салбарын байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, албан хаагчдад сургалт хийхтэй холбогдуулан зардал гаргасугай.

2. Шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 893,000 (Найман зуун ерэн гурван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100491